



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 184/Ш32019/02951

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг
баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.Лхагвасүрэн би “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжлэлтэй, С.Түвшинтулгад холбогдох иргэний хэргийг хүлээн авч хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК нь шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: Самдангийн Түвшинтулга нь Лэндмн ББСБ ХК-аас Лэндмн аппикейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2017 оны 09-р сарын 20-ны өдрийн 140,000 төгрөгийн зээлийг 13,500 төгрөгийн шимтгэлтэй 30 хоногийн хугацаатай 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй Хаан банкны 5019291005 тоот С.Түвшинтулгын дансанд шилжүүлсэн. Зээлдэгч С.Түвшинтулга нь хугацаандаа эргэн төлөөгүй тул 162,500 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК нь хариуцагч С.Түвшинтулгад холбогдуулан гэрээний үүрэг 162,500 төгрөг гаргуулах нэхэмжлэл гаргажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлж 162,500 төгрөгийг нэхэмжлэгчид бүрэн төлж барагдуулсан үндэслэлээр нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан талаар хүсэлтээ бичгээр ирүүлсэн байна.

Иймд нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн нэхэмжлэгч нэхэмжлэлээ татан авсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК нь хариуцагч С.Түвшинтулгад холбогдуулан гаргасан 162,500 төгрөг гаргуулах нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4-д зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 5,525 төгрөгийн тал хувь 2,762.5 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн Улаанбаатар хотын банк дахь 2601025961 тоот данснаас буцаан гаргуулж, нэхэмжлэгчид олгосугай.

3. Энэ захирамжид гомдол гаргах эрхгүйг дурдсугай.

ШҮҮГЧ

Ж.ЛХАГВАСҮРЭН